



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 495

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 242,000,000.00 (хоёр зуун дөчин хоёр сая) төгрөгийн балансын үнэ, 188,222,222.20 (нэг зуун наян найман сая хоёр зуун хорин хоёр мянга хоёр зуун хорин хоёр төгрөг хорин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг "Хөгжлийн-хөтөч дэд бүтэц" төсөлд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, "Хөгжлийн-хөтөч дэд бүтэц" төслийн нэгжийн зохицуулагч Ж.Ганбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.Нарангэрэл

Төрийн өмчийн бодлого  
зохицуулалтын газрын 2021 оны 11  
дүгээр сарын 11-ний өдрийн 495  
дугаар албан бичгийн хавсралт

"Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын дэмжих" төслийн үндсэн  
хөрөнгөд бүртгэлтэй "Хөгжлийн хөтөч дэд бүтэц" төслийн балансад  
шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашиглал тад орсон он	тоо шир хэг	Балансын үнэ/төгрөг/	Хуристлагдсан элэгдэл/төгрөг/	Үлдэгдэл өртөг /төгрөг/
1	Тоёото Ланд крузейр- 200 маркийн 01-85 УНЭ улсын дугаартай, суудлын автомашин, арлын дугаар JTMHX05J104130684	2017	1	242,000,000.0	188,222,222.2	53,777,777.8
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		1 (нэг)	242,000,000.00 (хоёр зуун дөчин хоёр сая)	188,222,222.20 (нэг зуун наян найман сая хоёр зуун хорин хоёр мянга хоёр зуун хорин хоёр төгрөг хорин мөнгө)	53,777,777.80 (тавин гурван сая долоон зуун далан долоон мянга долоон зуун далан долоон төгрөг наян мөнгө)